



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/06/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2024 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-
Undraa@audit.gov.mn](mailto:BatUndraa@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Гэрээт аудитор : Ц.Алтантуул

Утас: 91195554

Цахим хаяг: tuul9565@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.02.23 № 111

танай _____-ны № _____-т

ЗАВХАН АЙМГИЙН ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН ДАРГА
Ж.МӨНХЦЭЦЭГ-Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Завхан аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Завхан аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь 157.4 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнээс 1.07 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 156.1 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдсэн байна. Тайлант онд 18.5 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох газрын зөвшөөрөлтэйгээр данснаас хассан байна.

Аудитын гол асуудал

Завхан аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгуудад дүгнэлт өгөх аудитаар нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар хөтлөөгүй, орон нутгийн нэмэгдлийг журмын дагуу олгоогүй зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Бараа материалын тайланд бараа материалын хөдөлгөөний бүртгэл буруу илэрхийлсэн алдаа байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Audit(D)Дүгнэлт/2024

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох, бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Балансынүзүүлэлт	Эхнийүлдэгдэл	Эцсийнүлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>152,530,740.67</u>	<u>93,749,700.35</u>
	АВЛАГА	0	66,000.00
	Байгууллагаас авах авлага	0	66,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	152,530,740.67	93,683,700.35
351	Түүхий эд материал	133,769,520.67	70,343,175.35
35130	Эм боох материал	133,769,520.67	70,343,175.35
354	Хангамжийн материал	18,761,220.00	23,340,525.00
35410	Бичиг хэргийн материал	636,900.00	1,528,900.00
35420	Аж ахуйн материал	14,105,820.00	21,361,625.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,178,500.00	00.00
35440	Түлш,шатах тослох материал	520,000.00	450,000.00
35450	Барилгын засварын материал	2,320,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>324,596,058.20</u>	<u>459,792,420.07</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	324,596,058.20	459,792,420.07
392	Биетхөрөнгө	289,326,058.20	424,522,420.07
39201	Барилга, байгууламж, оронсууц	217,368,512.00	217,368,512.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-16,684,731.36	-20,803,414.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	150,118,000.00	131,618,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-113,113,833.31	-104,180,499.95
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	109,127,027.51	266,326,405.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-64,367,663.37	-72,705,713.39
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,006,627.00	9,216,627.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,954,510.27	-9,006,627.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,523,300.00	1,523,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,385,800.00	-1,523,300.00
39216	Дуусахгүй барилга,байгууламж	6,689,130.00	6,689,130.00
393	Биет бус хөрөнгө	35,270,000.00	35,270,000.00
39301	Програм хангамж	820,000.00	820,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-820,000.00	-820,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	35,270,000.00	35,270,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>477,126,798.87</u>	<u>553,542,120.42</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>00.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>477,126,798.87</u>	<u>553,542,120.42</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	477,126,798.87	553,542,120.42
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	283,361,967.00	283,361,967.00
51101	Өмч: - төрийн	283,361,967.00	283,361,967.00

512	Хуримтлагдсан үр дүн	168,453,565.66	244,868,887.21
51210	Өмнөх үеийн үр дүн	168,453,565.66	168,453,565.66
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	76,415,321.55
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	25,311,266.21	25,311,266.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	477,126,798.87	553,542,120.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	524,973,407.15	605,954,083.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	97,852,507.15	158,865,083.10
120	Нийтлэг татварын бус орлого	97,852,507.15	158,865,083.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	97,852,507.15	158,865,083.10
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	97,852,507.15	158,865,083.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	427,120,900.00	447,089,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	420,120,900.00	441,629,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	420,120,900.00	441,629,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,000,000.00	5,460,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,000,000.00	460,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	401,233,316.48	479,423,401.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	401,233,316.48	479,423,401.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	395,241,397.48	475,585,617.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	289,675,570.00	339,693,147.00
210101	Үндсэн цалин	289,675,570.00	339,693,147.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,021,069.00	46,089,691.00
210201	Тэтгэврийн даатгал	39,021,069.00	46,089,691.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,891,796.00	17,734,748.36
210301	Гэрэл, цахилгаан	1,840,992.00	2,647,508.36
210302	Түлш, халаалт	9,708,764.00	14,034,240.00
210303	Цэвэр, бохир ус	1,342,040.00	1,053,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,762,795.00	10,985,050.00
210401	Бичиг хэрэг	819,500.00	439,300.00
210402	Тээвэр, шатахуун	7,700,895.00	6,988,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,225,220.00	1,231,450.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	125,200.00	210,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,891,980.00	2,115,600.00
2105	Нормативт зардал	3,861,632.00	20,736,356.32
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,861,632.00	20,736,356.32
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,503,750.00	8,483,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	993,500.00	15,400.00
210604	Урсгал засвар	3,510,250.00	8,468,300.00
2107	Томилолт, зочны зардал	11,356,300.00	8,528,100.00
210702	Дотоод албан томилолт	11,356,300.00	8,528,100.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,894,715.00	1,121,809.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	270,075.00	215,825.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	424,084.00	146,184.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	396,000.00	308,000.00
210807	Газрын төлбөр	317,556.00	352,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,273,770.48	22,213,016.23
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,273,770.48	22,213,016.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,991,919.00	3,837,783.64
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,991,919.00	3,837,783.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,991,919.00	3,837,783.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>123,740,090.67</u>	<u>126,530,681.55</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	50,115,360.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	50,115,360.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-50,115,360.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>123,740,090.67</u>	<u>76,415,321.55</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>427,440,900.00</u>	<u>447,089,000.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	427,440,900.00	447,089,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	420,120,900.00	441,629,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	420,120,900.00	441,629,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,320,000.00	5,460,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,320,000.00	460,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>402,563,880.00</u>	<u>445,799,200.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	402,563,880.00	445,799,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	396,571,961.00	441,961,416.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	284,523,521.00	339,693,147.00
210101	Үндсэн цалин	170,632,654.00	198,016,542.00
210102	Нэмэгдэл	79,878,024.00	99,643,692.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,650,000.00	9,753,000.00
210104	Урамшуулал	23,362,843.00	32,279,913.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,988,217.00	46,155,691.00
210201	Тэтгэврийн даатгал	25,041,554.03	29,088,991.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,801,800.00	3,413,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,980,962.97	6,144,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	560,400.00	682,700.00

210205	Эрүүл мэндийн даатгал	5,603,500.00	6,826,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,741,801.00	17,734,748.36
210301	Гэрэл, цахилгаан	1,840,992.00	2,647,508.36
210302	Түлш, халаалт	8,558,769.00	14,034,240.00
210303	Цэвэр, бохир ус	1,342,040.00	1,053,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,890,010.00	14,981,750.00
210401	Бичиг хэрэг	898,800.00	1,331,300.00
210402	Тээвэр, шатахуун	7,934,700.00	6,918,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,225,220.00	1,231,450.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	125,200.00	210,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,706,090.00	5,290,300.00
2105	Нормативт зардал	23,793,017.00	7,300,371.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,415,517.00	6,350,371.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,377,500.00	950,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,988,380.00	6,445,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,585,900.00	1,335,000.00
210604	Урсгал засвар	9,402,480.00	5,110,800.00
2107	Томилолт, зочны зардал	11,356,300.00	8,528,100.00
210702	Дотоод албан томилолт	11,356,300.00	8,528,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,290,715.00	1,121,809.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	270,075.00	215,825.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	424,084.00	146,184.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	792,000.00	308,000.00
210807	Газрын төлбөр	317,556.00	352,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,991,919.00	3,837,783.64
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,991,919.00	3,837,783.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,991,919.00	3,837,783.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>24,877,020.00</u>	<u>1,289,800.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	24,877,020.00	1,289,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,877,020.00	1,289,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	24,877,020.00	1,289,800.00
222001	Тоног төхөөрөмж	24,877,020.00	1,079,800.00
223001	Бусад хөрөнгө	00.00	210,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-24,877,020.00</u>	<u>-1,289,800.00</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	283,361,967.00	25,311,266.21	168,453,565.66	477,126,798.87

D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	283,361,967.00	25,311,266.21	168,453,565.66	477,126,798.87
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	283,361,967.00	25,311,266.21	168,453,565.66	477,126,798.87
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	76,415,321.55	76,415,321.55
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	283,361,967.00	25,311,266.21	244,868,887.21	553,542,120.42

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	441,629,000.00	437,791,216.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	441,629,000.00	437,791,216.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	441,327,600.00	437,791,216.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	341,331,600.00	339,693,147.00
210101	Үндсэн цалин	200,024,800.00	202,204,688.00
210102	Нэмэгдэл	102,512,400.00	95,455,546.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,474,000.00	9,753,000.00
210104	Урамшуулал	26,320,400.00	32,279,913.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,080,000.00	46,155,691.00
210201	Тэтгэврийн даатгал	29,013,300.00	33,306,521.27
210202	Тэтгэмжийн даатгал	3,413,300.00	2,638,469.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,144,000.00	4,513,839.55
210204	Ажилгүйдлийн даатгал	682,700.00	518,087.45
210205	Эрүүл мэндийн даатгал	6,826,700.00	5,178,773.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,956,900.00	17,734,748.36
210301	Гэрэл, цахилгаан	2,525,200.00	2,647,508.36
210302	Түлш, халаалт	14,034,500.00	14,034,240.00
210303	Цэвэр, бохир ус	1,397,200.00	1,053,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,799,400.00	12,281,750.00
210401	Бичиг хэрэг	2,374,200.00	1,331,300.00
210402	Тээвэр, шатахуун	7,995,200.00	6,918,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	572,900.00	1,231,450.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	715,400.00	210,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,141,700.00	2,590,300.00
2105	Нормативт зардал	4,809,200.00	7,300,371.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,353,900.00	6,350,371.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-1,544,700.00	950,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,510,300.00	5,010,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,199,500.00	2,199,500.00

210604	Урсгал засвар	5,310,800.00	2,810,800.00
2107	Томилолт, зочны зардал	8,630,800.00	8,528,100.00
210702	Дотоод албан томилолт	8,630,800.00	8,528,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,209,400.00	1,087,109.00
210803	Даатгалын үйлчилгээ	215,900.00	215,825.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	181,400.00	146,184.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	101,500.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	392,500.00	308,000.00
210807	Газрын төлбөр	318,100.00	318,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	301400.00	0.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	301,400.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	301,400.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	441,629,000.00	441,629,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	441,629,000.00	441,629,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	441,629,000.00	441,629,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18.00	18.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн дагуу тусламж үйлчилгээ явуулдаг. Монголын уламжлалт анагаах ухааны түүхэн зүй тогтлыг алдагдуулахгүйгээр өнөөгийн шинэ шатанд гаргаж уламжлалт анагаах ухаан эмчилгээ үйлчилгээний цогц төв болж, иргэдэд уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх зорилт тавин ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын зөвлөл нь 2023 оны ажлын төлөвлөгөөндөө 5 ажил хийхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт бүрд удирдамж батлуулж, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгаж ажилласан байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 76,349.4 мянган төгрөгөөр буюу 11.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	152,530.70	93,683.70	(5,884.7)
Үндсэн хөрөнгө	324,596.00	459,792.40	135,196.40
Нийт хөрөнгө	477,126.70	553,476.10	76,349.40
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	477,126.70	553,476.10	76,349.40
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	477,126.70	553,476.10	76,349.40

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд:

Бараа материалын эхний үлдэгдэл 152,530.7 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 26,942.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 88,534.8 мянган төгрөг хасагдаж эцсийн үлдэгдэл 93,683.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,884.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 1,079.8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 156,119.5 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүгээр нэмэгдсэн байна. 18,500.0 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох шийдвэрийн дагуу акталж, жилийн эцэст 668,831.9 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 22,213.0 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 76,349.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 441,629.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 441,629.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 441,629.0 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 437,791.2 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байгаа нь хангамж, бараа материалын зардал хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
71601	Нийгмийн эрүүл мэнд				
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	441,629.0	437,791.2	3,837.8	99.1
НИЙТ		441,629.0	437,791.2	3,837.0	99.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3. Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 5,460.0 төгрөгийн орлого төвлөрүүлж, урсгал зардалд зарцуулсан байна.

4. Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2023 онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

5. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/Мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Шууд гэрээ байгуулах	Түлш халаалт	14,034.50	14,034.20
2	Шууд гэрээ байгуулах	Гэрэл цахилгаан	2,525.20	2,647.50
3	Шууд гэрээ байгуулах	Цэвэр, бохир ус	1,379.20	1,053.00
4	Шууд гэрээ байгуулах	Харилцаа холбооны зардал	572.90	1,231.50
5	Шууд гэрээ байгуулах	Тээвэр шатахуун	7,995.60	6,918.40
6	Шууд гэрээ байгуулах	Хог хаягдал зайлуулах	715.40	210.30
7	Шууд худалдан авалт	Багаж хэрэгсэл	2,199.50	2,199.50
ДҮН			29,422.30	28,294.40

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завхан аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Ари финайнс аудит” ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж, хяналтыг “Ари финайнс аудит” ХХК-ийн захирал Д.Ариунаа анхан шатанд хянаж, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ари финайнс аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 402,563.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,874.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,905.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 29 зүйл заалтаар хяналтыг хэрэгжүүлсэн ба алдаа зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант оны төгсгөлд дээд шатны төсөв захирагчаас цалин, нийгмийн даатгал болон хоолны зардлууд дээр төсөвт шаардлагагүй санхүүжилт нэмж олгосон байгааг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн 2,521.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 2,521.9 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3,384.0 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө

5.1 Төлбөрийн акт

2,521.9 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдлийг илүү тооцож олгосон төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага хүргүүлээгүй

5.3 Зөвлөмж хүргүүлээгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орон нутгийн нэмэгдлийг илүү тооцож олгосон	1	2,521.9	1	2,521.9								
Дүн	1	2,521.9	1	2,521.9								

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА ОГНОО: 2024-02-22

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР ОГНОО: 2024-02-22

АХЛАХ АУДИТОР

Ц.ОЮУНСУВД ОГНОО: 2024-02-22

АРИ ФИНАЙНС АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР

Ц.АЛТАНТУУЛ ОГНОО: 2024-02-22